



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

### Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,180,000,000 (нэг тэрбум нэг зуун наян сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг (Т.Энхзаяа)-т зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*В. Оюумаа* В.ОЮУМАА



1150500045

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2024 оны 02 дугаар сарын 06 -ний өдрийн  
 А/Н... дугаар тушаалын хавсралт



**Данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Тайлбар	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	мэргэжилтний санал	ҮХХХК-ын шийдвэр
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
<b>Тоног төхөөрөмж</b>													
1	Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр	3	Ш	2	590,000,000	1,180,000,000.00	590,000,000.00	589,999,999.90	Эрүүл мэндийн яамны нөөцөд бүртгэлтэй хөрөнгийг давхардуулж бүртгэсэн тул бүртгэлээс хасах	бүртгэлээс хасах	бүртгэлээс хасах	бүртгэлээс хасах	бүртгэлээс хасах
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>2</b>		<b>1,180,000,000.00</b>	<b>590,000,000.00</b>	<b>589,999,999.90</b>					
<b>Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө</b>													
<b>Татан төвлөрүүлэх</b>													
<b>Устгах хөрөнгө</b>													
<b>Худалдсанаас олох орлого</b>													
<b>НӨХГ-т төвлөрүүлэх (30%)</b>													